



ТҮМЭН ШУВУУТ
Аз жаргалыг үйлдвэрлэнэ

**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2023 оны 1.1 сарын 23 өдөр

№14/2023

Улаанбаатар хот

Залгамж халааны бодлого батлах тухай

“Компанийн засаглалын кодекс”-ийн Хоёрдугаар зарчмийн 2.4 дэх заалтыг хэрэгжүүлэх үүднээс Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааг төлөвлөх, компаний үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг хангахын тулд “Залгамж халааны бодлого”-ыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. “Залгамж халааны бодлого” батлагдсантай холбогдуулан Нэр дэвшүүлэх хорооны дарга /Г.Мөнх-Эрдэнэ/, Нэр дэвшүүлэх хорооны гишүүд /Б.Бархасбадь, А.Бакей/, болон Гүйцэтгэх захирал /Ж.Болд/ нарт энэхүү бодлогыг мөрдлөг болгон ажиллаж, ТУЗ-д тайлагнаж байхыг тус тус үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА  Л.ЭРХЭМБАЯР



“Түмэн шувуут” ХК-ийн ТУЗ-ийн
2023 оны 11 сарын 23 ний өдрийн
14/2023 тоот тогтоолын хавсралт



ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 “Түмэн шувуут” ХК-ийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааг төлөвлөх, компаний үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг хангахад оршино.
- 1.2 Компаний удирдах албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн оролцогч талууд хохирохгүй байх нөхцөлийг хангахын тулд эрх бүхий албан тушаалтны залгамж халааг тодорхойлоход оршино.
- 1.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь энэхүү бодлогыг хэрэгжүүлнэ.

ХОЁР. ЗАЛГАМЖ ХАЛААГ БЭЛТГЭХ

- 2.1 ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь залгамж халааны бодлогын баримт бичгийг боловсруулж, ТУЗ-д танилцуулна.
- 2.2 **ТУЗ болон Удирдах албан тушаалтнуудын залгамж халааны төлөвлөгөө**
 - 2.2.1 Нэр дэвшүүлэх хороо нь компанийн эрх бүхий албан тушаалд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтооно. Хороо нь компанийн хүний нөөц болон гаднаас эрх бүхий албан тушаалд тохирох нэр дэвшигчийг тодорхойлж, санал болгоно.
 - 2.2.2 ТУЗ-ийн гишүүн, удирдах албан тушаалд ажиллах хүнийг шинээр болон улираан нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх саналыг Нэр дэвшүүлэх хороо гаргах ба Компаний тухай хууль болон компанид хамаарах бусад хууль тогтоомж, дүрэм журмын холбогдох зүйл заалтуудыг мөрдлөг болгоно.
- 2.3 **Гүйцэтгэх удирдлагын багийн залгамж халааны төлөвлөгөө**
 - 2.3.1 Нэр дэвшүүлэх хороо нь гүйцэтгэх захирлын хамтаар гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдээс тухайн жилд тэтгэвэрт гарах эсвэл чөлөөлөгдөх хүсэлтэй хүн байгаа эсэхийг тодорхой давтамжтайгаар нягталж, хяналт тавина.
 - 2.3.2 Бизнесийн хэрэгцээ шаардлагын улмаас үйл ажиллагааг өргөтгөхтэй холбогдуулан шинээр гарч болзошгүй орон тоог Нэр дэвшүүлэх хороо болон гүйцэтгэх захирал санал болгон ТУЗ-ийн шийдвэрээр батална. Нэр дэвшүүлэх хорооноос компаний цаашдын өсөлт, хөгжилд тохирох нэр дэвшигчид бэлэн эсэхэд үнэлэлт дүгнэлт өгнө.
 - 2.3.3 Гүйцэтгэх удирдлагын баг болон чөлөөтэй орон тоо, томилгооны асуудлыг байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл, зорилго зорилттой уялдуулна.
 - 2.3.4 Гүйцэтгэх захирал нь хүний нөөцийн чиг үүргийн тусламжтайгаар албан тушаал дэвшин ажиллах чадварлаг ажилтнуудыг тодорхойлох ба санал болгох, ур чадварыг нь хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх,

хяналт тавих ба үнэлж дүгнэх, тусгай ажилтнуудад шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлон ажиллах зэргийг хариуцах ба Нэр дэвшүүлэх хорооноос шаардлагатай дэмжлэг туслалцаагаар хангана.

2.3.5 ТУЗ-өөс компанийн тодорхой чиг үүргийг удирдан ажиллах чадварлаг ажилтнуудыг олж тогтоох, хөгжүүлэхэд чиглэсэн дотоод бодлого, журмыг боловсруулах эрхийг Нэр дэвшүүлэх хороонд олгож болно.

ГУРАВ. ГЭНЭТИЙН ТОХИОЛДОЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭ БУЮУ ТҮР ТОМИЛГОО

- 3.1 ТУЗ-ийн гишүүн эсвэл удирдах албан тушаалтан нас барсан, өөр бусад гэнэтийн шалтгааны улмаас орон тоо нь чөлөөлөгдөх тохиолдолд Нэр дэвшүүлэх хороо яаралтай хуралдаж, орлох этгээдийг тодорхойлон холбогдох хууль тогтоомжийн дагуу томилгоог албажуулна.
- 3.2 Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн нас барсан, өөр бусад гэнэтийн шалтгааны улмаас орон тоо нь чөлөөлөгдсөн тохиолдолд Гүйцэтгэх захирал Нэр дэвшүүлэх хороотой зөвшилцөн орлох этгээдийг томилно.
- 3.3 Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтан урт хугацаанд өвчтэй, эсвэл чөлөөтэй байх үед түүний ажил үүргийг гүйцэтгэн орлох этгээдийг гүйцэтгэх захирал томилно. Нэр дэвшүүлэх хороо тус ажилтныг тухайн ажил үүргийг гүйцэтгэх чадваргүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай гүйцэтгэх захиралтай зөвшилцөн, томилгоог өөрчилж болно.
- 3.4 Гүйцэтгэх захирлаас бусад удирдах албан тушаалтнууд буюу дэд захирал, үйлдвэр, албаны дарга нар урт хугацаанд өвчтэй, эсвэл чөлөөтэй авах тохиолдолд орлон ажиллах этгээдийг гүйцэтгэх захирал томилно. Нэр дэвшүүлэх хороо тус ажилтныг тухайн ажил үүргийг гүйцэтгэх чадваргүй гэж үзсэн тохиолдолд гүйцэтгэх захиралтай зөвшилцсөний үндсэн дээр томилгоог өөрчилж болно.

ДӨРӨВ. ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ СУРГАЛТ, ХӨГЖИЛ

- 4.1 ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах, чиглүүлэх сургалт нь ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг мэдээллийг олгох сургалтын агуулгатай байна. Чиглүүлэх сургалтын хүрээнд доорх агуулга /зөвхөн эдгээрээр хязгаарлахгүй/-ыг ТУЗ-ийн шинэ гишүүнд бичгээр танилцуулж, гарын үсэг зуруулан баталгаажуулна.
 - 4.1.1 Цалин урамшуулал
 - 4.1.2 Үүрэг хариуцлага
 - 4.1.3 Компанийн дотоод дүрэм, журам
- 4.2 ТУЗ-ийн гишүүний мэдлэг чадварыг тогтмол дээшлүүлэх, цаг үеийн мэдээллийг олгоход Компанийн зүгээс сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ба тус сургалтын хөтөлбөрийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо баталж, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зохион байгуулна. Шинэчлэх сургалтад дараах агуулга хамаарах боловч зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй.
 - 4.2.1 Компанийн дотоод дүрэм, журмууд
 - 4.2.2 Зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм, журмууд
 - 4.2.3 Компанийн засаглалын шилдэг туршлага

4.2.4 Авлига, албан тушаалын гэмт хэргээс сэргийлэх

4.3 ТУЗ-ийн гишүүнд зориулсан сургалт нь зайны, танхимын, бизнес аялалын хэлбэртэй байж болно.

4.4 Сургалтын зардлыг компани бүрэн хариуцна.

ТАВ. БУСАД

5.1 Энэ баримт бичгийн хэрэгжилтэд Нэр дэвшүүлэх хороо хяналт тавьж ажиллах ба гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг ТУЗ эдэлнэ.

5.2 Компанийн тухай хууль, түүний хүрээнд батлагдсан журмууд, СЗХ-ны баталсан дүрэм, журам тэдгээрийн шинэчилсэн хувилбар болон бусад хууль журмаар шаардсан тохиолдолд энэхүү бодлогын талаарх мэдээллийг компанийн жилийн тайланд оруулж, бодлогын баримт бичгийг компанийн цахим хуудсанд байршуулна.

* * *